

ТӨРИЙН УДИРДЛАГА, УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ОНОЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

“ТӨРИЙН УДИРДЛАГА” ХӨТӨЛБӨРИЙН ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛ (ШУТИС-ИЙН ЖИШЭЭН ДЭЭР)

Б. Долгор

*Доктор (Ph. D.), профессор
Шинжлэх ухаан, технологийн их сургууль. Бизнесийн удирдлага,
хүмүүнлэгийн сургууль*

dolgor@must.edu.mn

Д. Одмаа

*Доктор (Ph. D.), дэд профессор
Шинжлэх ухаан, технологийн их сургууль. Бизнесийн удирдлага,
хүмүүнлэгийн сургууль*

odmaadangaa@gmail.com

Хураангуй: Орчин үеийн шинжлэх ухааны ололт, дэлхийн улс гүрнүүдийн нийгэм, улс төр, эдийн засгийн олон талт байдал, техник технологийн хөгжил, мэдээллийн хурдац, соёлын нэвтрэлцээ зэрэгтэй холбон үзвэл их дээд сургуулиудад мэргэжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь улс үндэстний онцлог, орон зай, цаг хугацаанаас үл хамаарсан глобал асуудал болоод байна. Мэдээлэл харилцаа өргөжиж, хувь хүний бие даасан байдал /индивид шинж/ хурдацтай өөрчлөгдөж буй нь нийгмийн бүхий л институцид нөлөөлөх болжээ. Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхэд төрийн /нийтийн/ албаны үүрэг, оролцоо ялангуяа тухайн чиглэлээр сургалт явуулж судалгаа хийдэг их дээд сургуулиуд, судалгааны байгууллагуудын мэргэжлийн хөтөлбөр, судалгааны чиглэл нь чухал нөлөө үзүүлэхүйц байх нь хөгжлийн шалгуур үзүүлэлтийн нэг болоод байна. Иймд Монголд “Төрийн захиргааны менежмент” мэргэжлээр 1998 оноос сургалт явуулж эхэлсэн анхдагч сургуулиудын нэг ШУТИС-ийн жишээн дээр одоогийн “Төрийн удирдлага”-ын бакалаврын хөтөлбөрийн өөрчлөлт, шинэчлэлийн асуудлыг судлахыг гол зорилгоо болголоо.

Түлхүүр үгс: Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, нэршил, кредит цаг, хичээл

УДИРТГАЛ

2010-2021 онд хэрэгжих Монгол улсын дээд боловсролын шинэчлэлийн зураглал /roadmap/-д [1] дээд боловсролын сургалтын хөтөлбөрийг олон улсын стандартад бүрэн нийцүүлэх, судалгааны ажлын чиглэл нь зах зээлийн хэрэгцээ шаардлагыг хангасан үр дүнтэй улс орны

хөгжилд өгөөжтэй байх, их дээд сургуулиар бэлтгэгдэж байгаа мэргэжилтэн түүний төлөвлөлт нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй холбогдох зэрэг олон асуудлыг тодорхой заасан байна. Манайд хэрэгжиж буй дээд боловсролын шинэчлэл нь боловсролын байгууллагын олон талыг хамарсан, олон шинэлэг ажлууд хийгдэж буй хэдий ч хүссэн үр дүнд хүрэх, олон улсын жишигт хараахан ойртох болоогүй байна. Даяаршлын энэ эринд гагцхүү нэг улс, үндэстэнд тохирсон боловсролын тогтолцоо гэж байх боломжгүй мэт боловч, улс орон, үндэстнийхээ боломж бололцоо, онцлогт нийцсэн боловсролын буюу хүн ардынхаа сэтгэлгээг зөв зохистой төлөвшүүлж хөгжүүлэх, хүмүүжүүлэн сургах тогтолцоотой байх нь туурга тусгаар улс, төр засгийн үүрэг, бахархал төдийгүй, ёстой нөгөөх “хар” эсвэл “алтан хайрцагны бодлого” байх ёстой бус уу?” гэсэн судлаачийн санааг анхаарах хэрэгтэй. Ялангуяа цаашид хөгжлийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий нийгмийн харилцааны тулгуур болсон төрийн захиргаа-төрийн удирдлагын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж буй их дээд сургуулиудад нэгдсэн бодлого, тогтсон хандлага, сургалт судалгааны концепци шаардлагатай байна. Орчин үеийн их сургуулиуд академик сургалтаас аль болох татгалзан нээлттэй, прагматик нийтийн боловсрол олгох чиглэл рүү явж байгаа нь мэдлэг болон боловсролын хүртээмжийг сайжруулах, хөрвөх чадвартай дэлхийн иргэнийг бэлтгэх, нийгмийн инновацийг хэрэгжүүлэх зэрэг олон шаардлагад нийцсэн дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх асуудалд чиглэгдэж байна.

Их сургууль гэдэг бол эрдэм мэдлэгийн мөр хөөсөн бүлэг, хүмүүсийн нийгэмлэг бөгөөд үзэл санааны ялгаатай иргэд нэгэн дор цуглаж өөрсдийн сэтгэлгээний явцуу байдлаа даван гарах, ертөнцийн тухай хамгийн түгээмэл утгаар шүүн хэлэлцэх гэдэг утгаар XII зуунд Газар дундын тэнгист (Умард Италид үүссэн түүхтэй. Дундад зууны үед их сургуулиуд нийгмийн бусад институциудтай ихээхэн зөрчилддөг байсан учраас эзэн хаан их сургуулиудыг ивээлдээ авч онцгой эрх дарх эдлүүлдэг, хамгаалдаг байжээ [2]. ХҮ-ХІХ зууны Баруун Европт нийгэм эдийн засгийн амьдралд өөрчлөлт гарч шинжлэх ухааны бүхий салбарууд рациональ хандлага гарч ирснээр дээд боловсролын бие даан хөгжих эхлэл тавигджээ. ХХ зууны дунд үеэс их сургуулийн хил хязгаар тэлж, боловсролын даяаршил хүчтэй явагдаж байна. Энэ нь манай дээд боловсролын үндсэн хандлагыг тодорхойлох боллоо. Нийгмийн харилцаанд оролцогч талууд олшрохын хэрээр зорилтот ба зорилтот бус бүлэг, иргэд-олон нийт, төрийн болон төрийн бус байгууллага, бизнесийн байгууллага, улс төрийн намуудын дотоод, гадаад коммуникацийг өргөжүүлэхэд иргэний нийгмийн үндсэн институци төрийн удирдлага (нийт) - ын үүрэг оролцоо улам нэмэгдэж байгааг дээр өгүүлсэн. Энэ үүргийг гүйцэтгэхэд

их, дээд сургуулийн бодлого төлөвлөлт, сургалт, судалгааны ажлын хөтөлбөрийн шинэчлэл зэрэг нь чухлаар нөлөөлдөг учраас уг сэдвийг сонгон өгүүлэл бичсэн болно.

ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Сургалтын хөтөлбөрийн онол, арга зүй. XX зууны сүүл үеэс боловсролын тогтолцоонд бодлогын хувьд шинэ, шинэ өөрчлөлт хийгдэх болсонтой зэрэгцэн киррикулим гэсэн ойлголт гарч ирсэн. Энэ үеэс киррикулимыг боловсролын бодлогын хэрэгсэл гэдэг талаас нь авч үзэх байдал нэмэгдэж, боловсролын стандарттай хамтатган, чанарыг дээшлүүлэх нэг гол хүчин зүйл гэж үнэлэх болсон [3]. Киррикулим хэмээх энэ ойлголт монголын боловсрол судлалд орж ирэхдээ нэлээд онолжсон, танин мэдэхүйн шинжтэй байв [4] Сургалтын хөтөлбөрийн талаар олон эрдэмтэд өөрсдийн үзэл баримтлалыг дэвшүүлсэн байдаг. Тухайлбал, Америкийн судлаач Франклин Бобит сургалтын хөтөлбөрийг шинжлэх ухаан болохыг нотолж, суралцагчдын хэрэгцээнд тулгуурлан боловсруулахын ач холбогдлыг онцгойлон дурдсан бол Америкийн судлаач Верэт Чартерс сургалтын хөтөлбөрийг оюуны хэрэгцээнд тулгуурласан, багшийн хичээлийг удирдан явуулах төлөвлөгөөг багтаасан шинжлэх ухаан гэж тайлбарласан байдаг. Харин судлаач Холис Касвэл түүнийг нийгмийн шаардлагад нийцсэн агуулга бүхий зохион байгуулагдсан мэдлэг хийгээд суралцагчдын хэрэгцээнд тулгуурлан боловсруулах ёстой гэж үзжээ. Судлаач Ральф Тайлер сургалтын хөтөлбөрийг тухайн сургуулийн философи үзэл санааг дэлгэрүүлсэн, суралцагчдын хэрэгцээ шаардлагад үндэслэсэн шинжлэх ухаан гэж үзсэн. Судлаач Ц.Лувсандорж сургалтын хөтөлбөрийг суралцагчдын хэрэгцээ, тэдгээрийн талаарх үзэл, зорилго, зорилт, судлах агуулга, сургалт явуулах арга зам, үнэлгээ гэсэн 5 хэсэг бүхий тогтолцоо юм гэсэн байна [5]. Дээрх судлаачдын дэвшүүлсэн үзэл баримтлалыг ерөнхийд нь авч үзвэл суралцагчдын хэрэгцээнд тулгуурласан, тухайн хичээлийг удирдан явуулах төлөвлөгөө бүхий албан ёсны сургалтын баримт бичиг гэж үзэж болохоор байна. Их, дээд сургуулиуд сургалтын хөтөлбөр боловсруулах нь тэдгээрийн үндсэн үйл ажиллагааны нэг чиглэл [6] бөгөөд нийгмийн шаардлага, эрэлт хэрэгцээнд тулгуурлан хөтөлбөрийн өөрчлөлт, шинэчлэлийг хийж байна.

Сургалтын хөтөлбөрийг боловсруулах талаар дараах онолууд түгээмэл дэлгэрсэн байдаг.

Дидактик (Didactic) - ийн онол. Сургалтын үйл явцыг төлөвлөх зохион байгуулах нэг онол нь дидактикийн онол юм. Дидактик нь “Didaktikos”-сургах, “Didasko”-сурах, судлах гэсэн утгатай грек үгнээс гаралтай. Германы сурган хүмүүжүүлэгч Вольфганг Радке (1571-1635) энэ

үгийг “Сургах урлаг” гэсэн утгаар авч хэрэглэсэн бол Чехийн нэрт сурган хүмүүжүүлэгч Я.А.Коменский (1592-1670) “Бүхнийг бүгдэд сургах түгээмэл урлаг” хэмээн тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл дидактик нь боловсрол, сургалтын зорилго, агуулга, арга хэрэгсэл, зохион байгуулалт, хүрэх үр дүнгийн тухай шинжлэх ухаан мөн. Дидактикийн онолд сургалтын хөтөлбөр нь үзэл баримтлал, зорилго зорилтууд, агуулга, аргазүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдтэй [7] бөгөөд дараах онцлогтой.

- Судлагдахуун төвтэй, мэдлэгт суурилсан;
- Нийгмийн хэрэгцээн дээр үндэслэдэг;
- Цөм хөтөлбөрийн хүрээнд сургууль, багш баяжуулж хэрэглэх боломжтой;
- Багш мэдээлэл дамжуулах, цээжлэн тогтоолгох арга зүйд түшиглэдэг;
- Агуулгын хувьд тогтвортой;
- Онолын мэдлэг түлхүү олгож, академик сургалтыг чухалчилдаг байна.

Киррикулум (Curriculum) - ын онол. Боловсролын хүрээнд сургалтын үйл явцыг төлөвлөх, зохион байгуулах киррикулимийн онол ХХ зууны 20-иод оноос сургалтанд нэвтэрч эхэлсэн гэж судлаачид үздэг. Уг онол нь анх төвлөрсөн бус боловсролын тогтолцоотой, сургалтад олон хэлбэрээр хандах эрэл хайлт хийж байсан Англи-саксоны соёлтой улс орнуудад туршилтын замаар үүсжээ. Киррикулимийн онол нь сургах, суралцах үйл ажиллагаа, түүний орчин нөхцлийг харилцан хамааралд нь бүхэл бүтэн үйл ажиллагааны тогтолцоо байдлаар авч үздэг. Киррикулум нь үндэслэл буюу үзэл баримтлал, зорилго, зорилт, хамрах хүрээ, агуулга, аргазүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ гэсэн бүтэцтэй бөгөөд дараах онцлог шинжтэй.

- Цогц чадамжид суурилсан;
- Хувь хүний хэрэгцээн дээр үндэслэдэг;
- Цогц чадамжид баримжаалан агуулгын айн хүрээнд сургууль, багш нар өөрсдөө сонгон хэрэгжүүлэх боломжтой;
- Агуулгыг эзэмшүүлэхдээ мэдлэг бүтээлгэх, мэдлэгээ хэрэглээ болгох арга зүй давамгайлдаг;
- Агуулгын хувьд нээлттэй
- Прагматик сургалтыг чухалчилдаг байна. [8]

Киррикулум нь хөгжлийн явцад олон хэлбэрээр хөгжиж байгаа бөгөөд эдгээрээс дидактик киррикулум, конструктивист киррикулимийн ялгааг дараах байдлаар авч үзлээ. Дидактик киррикулум нь эмх цэгцтэй мэдлэг олгох, мэдлэгийг цээжлэн тогтоох, сахилга баттай байх, анхаарлаа

төвлөрүүлэх зэргийг чухалчилан авч үздэг бол конструктивист киррикулим нь судалгаа шинжилгээ хийх, мэдлэг бүтээх, тодорхой түвшинд сэтгэн бодох, төрөл бүрийн эх сурвалжууд дээр ажиллах зэрэг цогц асуудлуудыг шийдвэрлэхийг гол үзэл баримтлалаа болгодог [9].

Чадамжид суурилсан хөтөлбөр (Competence-based curriculum)-ийн онол. Дэлхий дахинд хүний нөөцийн бодлого, хүний чадамжийг дээшлүүлэх нь боловсролын зорилго болон тавигдаж, боловсролын үр дүнг хүнтэй, хүний чадамжтай холбон ойлгож түүгээр хүрэх үр дүнгээ баримжаалах боллоо. Чадамжид суурилсан хөтөлбөрийн онол нь боловсролын үйл явц дахь XXI зууны онол гэж нэрлэгддэг бөгөөд АНУ, Европын орнуудын дээд болон мэргэжлийн боловсролын салбарт өргөнөөр хэрэглэгдэж байгаа [10].

“Competence” гэдэг нийтлэг ухагдахууныг бид төрөлх хэлээрээ “чадамж” хэмээн хөрвүүлэн хэрэглэж байна. Чадамж гэдэг нь сургалтын явцад олж авсан мэдлэг, эзэмшсэн туршлага авъяасаар үнэлэгдэнэ. Үйлдлийг гүйцэтгэх мэдлэг нь чадварыг бий болгодог. Чадамж нь үйлдлүүд болон чадварын цогц юм [11]. Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Чадамжийн хүрээ (Хөтөлбөрийн зорилго зорилт, бүтэц, зохион байгуулалт);
- Багшийн гарын авлага, удирдамж (Сургах үйл ажиллагаа);
- Суралцагчийн гарын авлага, удирдамж (Сурах үйл ажиллагаа);
- Үнэлгээ орно.

Чадамжийн хөтөлбөрийн бүтэц нь ерөнхий суурь чадамжийн нэгжүүд, мэргэжлийн суурь чадамжийн нэгжүүд, мэргэшүүлэх чадамжийн нэгжүүдээс бүрдэх ба сайн боловсруулсан чадамжид суурилсан хөтөлбөр нь сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх, суралцах хугацааг богиносгох, оюутныг бодитой үнэлэх нөхцлийг хангаж өгдөг [12]. Мөн дээд боловсролтой мэргэжилтнийг мэргэжлийн ажилчдад байдаг шиг тийм чадвар, чадамжтай болгож төгсгөх боломжтой [13]. Чадамжид суурилсан хөтөлбөрийн сургалтын арга зүй нь дараах онцлогтой байдаг.

- Суралцагчдын авъяас чадварыг хөгжүүлснээр хувь хүн амжилтанд хүрэх арга зүйг бүрдүүлдэг
- Суралцагчийн сурах арга барилыг хөгжүүлэхэд чиглэгддэг ба тэд өөрийн үйл ажиллагаагаар мэдлэг бүтээж, чадвар, дадал, төлөвшлийг олж авдаг
- Суралцагч бүрт бие даан суралцах чадамжийг бий болгодог бөгөөд тэд сургалтын үйл явцад хариуцлагатай, идэвхтэй оролцдог
- Суралцагчдад богино хугацаанд сурах боломжийг бүрдүүлдэг
- Багш суралцагчдад сургалтын идэвхтэй аргуудыг санал болгодог

- Багш суралцагч хамтран ажиллаж, зорилгоо биелүүлдэг.

Эдгээр онолуудыг харьцуулж үзвэл сургалтын хөтөлбөр нь үндсэн 4 бүтэцтэй байж болох юм.

Зураг 1. Сургалтын хөтөлбөрийн бүтэц



Эх сурвалж: Зохиогчийнхоор

Иймд уг өгүүлэлд дээрх загварыг судалгааны онол, арга зүйн үндэс болгон баримт бичгийн судалгаа хийсэн болно.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Орчин үеийн шинжлэх ухааны хандлага нь аливаа нэгэн онол, үзэл баримтлал, үйл явцыг илүүд тооцох бус иргэд олон нийтийн сэтгэл зүй, үнэт зүйлд тулгуурлан юмс үзэгдлийг олон ургальч санааны үүднээс авч үзэхэд чиглэсэн, шинэлэг байдлаар хөгжиж байна. Төрийн удирдлага гэдэг нэр томъёог нь:

- Төрийн захиргаа
- Төрийн удирдлага
- Нийтийн удирдлага
- Нийтийн захиргаа
- Төрийн захиргааны менежмент
- Төрийн захиргааны удирдлага
- Төрийн байгууллага зэрэг утгаар ялгаатай тайлбарлах нь түгээмэл байна.

Монголчууд “улс” гэдгийг “төр”-өөр төлөөлүүлэх нь нийгмийн стереотип дэх түгээмэл ойлголт юм. Я.Цэвэлийн Монгол хэлний товч тайлбар тольд “Төр бол улс гүрэн, улсын засаг, ёс, хууль цааз, нэр сүр, алдар” гэсэн утгаар авч үзсэн нь бий. Монголын хууль зүйн толь бичгүүдэд “Civil service” буюу төрийн иргэний байгууллагын алба, яамны аппаратын түшмэл, байгууллагын аппарат, “Public service” буюу олон нийтийн үйлчилгээ, нийтийн чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн алба хэмээн

тайлбарлахаас гадна БНСУ-ын Хууль зүйн судалгааны хүрээлэн, Монголын Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хамтран гаргасан “Англи-Солонгос-Монгол-Орос-Герман хууль зүйн толь”-т бичигт public-공적인-төрийн, улсын, нийтийн (государственный, публичный, общественный) гэсэн адил утгаар дурджээ. Академич Ж.Амарсанаа дээрхийн адил “public - государственный, публичный, общественный төрийн, улсын, нийтийн” гэж үзсэн байна. Төрийн удирдлагыг Монголчуудын уламжлалт сэтгэлгээтэй холбон үзвээс:

- Төрийг “хаан” хэмээн үзэх нь хувь хүнтэй /индивид/ холбоотой бөгөөд хаан нь хүлээн зөвшөөрөгдсөн байх учиртай. (Шалгуур нь удам угсаа, дээд тэнгэрээс заяат байх)
- Нүүдлийн иргэншил, ахуйтай холбож үзвэл (Тархай бутархай натурал аж ахуйн хувьд олон нийтийг хамарсан хүчтэй удирдлага тухайлбал, хаан, ноёнттой байж нийгмийг зохион байгуулалтанд оруулна)

Суурьшмал соёл иргэншилтэй улс орнуудын төр ёсны сэтгэлгээтэй холбон үзвэл:

- Хамтын хүчээр амьдрал ахуйгаа зохион байгуулдаг учир нэгдсэн удирдлагын аппарат шаардлагатай. (Энэ нь үйлдвэрлэл, хөдөлмөрийн хуваартай холбоотой)
- Эрх мэдлийг олж авах, тогтоон барихтай холбоотой асуудал юм. (Олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөхийн тулд улс төрийн сонгууль, PR, коммуникаци хийх)

Уг ухагдахууныг өнөөгийн энгийн ухамсрын түвшинд авч үзвэл: Төрийн удирдлага улс төрөөс ангид оршдоггүй бөгөөд нийтийн үйл ажиллагаа юм. Улс төрийн эрх мэдлийг авсан намын үзэл баримтлалд ч төрөөр дамжин хэрэгждэг байх ёстой ажээ. Орчин үед төрийн удирдлагыг шинжлэх ухааны бүтцийнх нь хувьд дараах байдлаар тодорхойлж байна [14] . Үүнд:

- Улс төр
- Хууль, эрх зүй
- Менежмент
- Ажил мэргэжил

Ер нь төрийн удирдлага нь олон шинжлэх ухааны уулзварт хөгжиж байж зорилгоо хангадаг.

- Улс төрийн шинжлэх ухаан - Төрийн бодлого судлал, улс төрийн прогнозчлол болон сэтгэлгээний түүх, детерменизм, геополитик, захиргааны газар зүй
- Хууль, эрх зүйн шинжлэх ухаан - Үндсэн хууль болон бусад хууль, эрх зүйн акт

- Удирдахуйн ухаан - Менежментийн арга технологи - Манлайлал зэрэгтэй холбоотой хөгжиж байна.

Хамгийн өргөн утгаар авч үзвэл төрийн удирдлага нь нийтийн төлөөх бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх олон талт, тасралтгүй үйл явцын цуваа юм. Нийтийн төлөөх бодлого нь:

1. Засаг, төрийн үйл ажиллагаа
2. Бодит хэрэгцээ буюу асуудалд хандсан
3. Зорилгод чиглэсэн
4. Үйл ажиллагааны стратеги
5. Ямар нэгэн зүйлийг хийх, эсвэл хийхгүй байх шийдвэр
6. Нэг буюу хэд хэдэн оролцогч талуудын ажиллагаа
7. Үйл ажиллагааны үндэслэл
8. Шийдвэр гаргалт

Нийтийн төлөөх төрийн бодлогыг хүрээгээр нь:

- Үндэсний болон хэд хэдэн улсын хэмжээний макро түвшин
- Тодорхой нэг хүрээ, чиглэлд хамаарах мета түвшин
- Орон нутгийн асуудлыг шийдвэрлэх микро түвшинд авч үзэхээс гадна нийт улсын, бүс нутгийн, орон нутгийн бодлого зэргээр тайлбарладаг.

Дээрх үндэслэлүүдээс үзвэл Төрийн удирдлага нь өргөн утгаараа төрийн бодлого болон хөтөлбөрийг хэрэгжүүлэгч (зохион байгуулагч) ба төрийн албан хаагчдын зан үйлийн төлөө хариуцлага хүлээх институци юм.

Улс орон зах зээлийн харилцаанд шилжиж дээд боловсролын систем либералчлагдснаар олон өөрчлөлт гарсны нэг бол ШУТИС-д инженер, технологич бэлтгэж ирсэн арвин туршлага, материаллаг бааз, профессор багш нарын оюуны их нөөцөд түшиглэн нийгэм, менежмент, бизнес, хүмүүнлэгийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэх болсон явдал юм. Нийгмийн тогтолцоо өөрчлөгдөн, төрийн бодлогод шинэчлэлийн үзэл санаа гүнзгий тусах болсон нь тухайн цаг үеийн өвөрмөц үзэгдэл бөгөөд энэ үед улс төр, менежмент, хууль эрх зүйн шинжлэх ухаануудын уулзварт бэлтгэгддэг *“Шинэ мэргэжил”* төрөн гарснаар дээд боловсролын болон төрийн албаны шинэчлэлд цаг үеэ олсон парадокс байлаа. Үүний нэг илрэл нь БСШУ-ны сайдын 1996 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн “Сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл” (№960009) олгох тухай 84-р тушаалыг үндэслэн 1998-1999 оны хичээлийн жилд ШУТИС-ийн харьяа КТМС-д “Төрийн захиргааны менежмент” мэргэжлээр элсэлт авч, анхны сургалтаа явуулж эхэлсэн явдал юм [15]. Тус мэргэжил нь тухайн үеийн КТМС-ийн “Үйлдвэрлэлийн технологийн удирдлагын тэнхимд “Төрийн захиргааны менежмент” нэртэйгээр, D340200 индекстэйгээр нээгдэж байсан. Энэ хугацаанд “Төрийн

удирдлага” мэргэжлийн хөтөлбөрөөр нийт 220 бакалавр, 100 гаруй магистр төгсгөсөн бөгөөд одоо тус хөтөлбөрт 109 бакалавр оюутан, 28 магистрант, 2 докторант суралцаж байна [16].

Өнөөдөр улсын хэмжээнд 94 дээд боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас [17] 10 их дээд сургууль энэ мэргэжлээр сургалт явуулж байна.

Хүснэгт 1. Төрийн удирдлага хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиуд

№	Сургуулийн нэр	Хөтөлбөрийн нэр	Сургалтын чиглэл
1	ШУТИС, Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн сургууль	Төрийн удирдлага	Бакалавр Магистр Доктор
2	МУИС, Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын сургууль	Нийтийн удирдлага	Бакалавр Магистр Доктор
3	Удирдлагын Академи	Төрийн захиргааны менежмент Төрийн удирдлага Нийтийн удирдлага	Мэргэшүүлэх диплом Магистр Доктор
4	ҮБХИС, Аюулгүй Байдлын сургууль	Нийтийн удирдлага	Бакалавр Магистр
5	Орхон их сургууль	Нийтийн удирдлага Төрийн захиргааны менежмент	Бакалавр Магистр
6	Этүгэн их сургууль, Инженерчлэл-Эдийн засаг, Менежментийн сургууль	Төрийн захиргааны удирдлага	Бакалавр Магистр
7	МУИС, Эдийн засаг, бизнесийн удирдлагын сургууль	Нийтийн удирдлага Орон нутгийн өөрийн удирдлагын мэргэжилтэн	Бакалавр
8	Монголын Рояаль Академи	Нийтийн удирдлага (Төрийн)	Бакалавр Магистр
9	Цэцээгүн Менежментийн дээд сургууль	Нийтийн удирдлага	Бакалавр Магистр
10	Засагтхан дээд сургууль	Төрийн удирдлага	Магистр

Эх сурвалж: Зохиогчийнхоор

Дээрх хүснэгтээс харвал “Төрийн удирдлага” хөтөлбөр нь харилцан адилгүй бүрэлдэхүүн сургууль, салбар, нэгжүүдэд харъяалагдахын зэрэгцээ мөн 4 өөр нэршлээр нэрлэгдэж байна. ШУТИС, МУИС гэсэн 2 сургуулийн тухайд бакалавр, магистр, докторын 3 шатны сургалтыг явуулдаг бол дийлэнх сургууль нь бакалавр, магистрын хөтөлбөр хэрэгжүүлдэг ажээ. ШУТИС, Засагтхан дээд сургууль Төрийн удирдлага; МУИС, ҮБХИС, Цэцээгүн менежментийн дээд сургууль, Орхон их сургууль, Улаанбаатар их сургууль, МУИС, Монголын Рояаль академи Нийтийн удирдлага; Этүгэн их сургууль Төрийн захиргааны удирдлага хэмээн нэрлэж байна.

Баримт бичгийн судалгааны хамрах хүрээг ШУТИС-ийн “Төрийн удирдлага” -ын бакалаврын хөтөлбөрөөр хязгаарлаж, сургалтын хөтөлбөрийн 4 үндсэн бүтцийн агуулгын хүрээнд авч үзлээ. Хөтөлбөрийн

үзэл баримтлалын хүрээнд хөтөлбөрийн нэршлийн асуудлыг, хөтөлбөрийн агуулга, арга зүйн хүрээнд сургалтын төлөвлөгөөний өөрчлөлт болон мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлүүдийн өөрчлөлтийн асуудлыг, хөтөлбөрийн орчны хүрээнд хөтөлбөрийн шууд харъяалагдах нэгжийн өөрчлөлт, ном сурах бичгийн хангамжийн асуудлыг, хөтөлбөрийн үнэлгээний хүрээнд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдлыг тус тус хамруулан судалсан.

ШУТИС-ийн “Төрийн удирдлага” бакалаврын хөтөлбөрийн тухайд 20 жилийн хугацаанд дараах өөрчлөлтүүд гарсан гэж үзэж болохоор байна. Үүнд:

1. Хөтөлбөрийн нэршлийн өөрчлөлт. 1998 онд уг мэргэжил “Төрийн захиргааны менежмент” нэртэйгээр элсэлт авч эхэлсэн бол БСШУ-ны сайдын 2014 оны А/78 тоот тушаалаар мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлагдахад хөтөлбөрийн нэр өөрчлөгдөж “Нийтийн удирдлага (D041303)” болсон. Харин БСШУС-ын сайдын 2017 оны 06 сарын 29-ний өдрийн А/52 тоот тушаалаар хөтөлбөрийн нэрийг “Төрийн удирдлага (D041303)” болгон өөрчилсөн. Өнөөдрийг хүртэл уг мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж буй сургуулиудад дээрх байдлаар янз бүрээр нэрлэсэн хэвээр байна.

2. Хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний өөрчлөлт. 1998, 2007, 2014, 2016 онуудад тухайн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө өөрчлөгдөж байсан. Дээрх өөрчлөлтүүдэд дээд боловсролын шинэчлэл, сургуулийн бодлого, сургуулийн бүтэц зохион байгуулалт, нийгмийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчдын санал санаачилга, төгсөгчдийн судалгааны үр дүн зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж байсан гэдэг нь тодорхой юм.

*Хүснэгт 2. Сургалтын төлөвлөгөөний өөрчлөлт
(Кредит цагаар)*

Хичээл	1998	2007	2014	2016
Дээд боловсролын суурь	45	46	33	36
Мэргэжлийн суурь	39	45	33	33
Мэргэжлийн	30	32	47	41
Дадлага	3	2	5	6
Диплом	5	5	5	5
Нийт кредит	122	130	123	121

Эх сурвалж: Зохиогчийнхоор

Сургалтын төлөвлөгөөний өөрчлөлтөд эрс шинэчлэл хийсэн байдал харагдахгүй байгаа бөгөөд зөвхөн кредит цагийн өөрчлөлт, хичээлийн нэршил, код, өмнөх холбоо зэргээр л хязгаарлагдаж байна. Харин анхны сургалтын төлөвлөгөөнд тусдаа дадлагын хичээл тусгагдаагүй ч оюутанд олгох мэргэжлийн ур чадвар, дадлыг Төрийн удирдлага төсөл хичээлийн хүрээнд 3 кредит үздэг байв (КТМС, 2002, хууд. 48). Түүнчлэн

мэргэжлийн хичээлийн эзлэх хувь өсч, дээд боловсролын суурь хичээлүүдийн эзлэх хувь буурсан байна.

Түүнчлэн сургалтын төлөвлөгөөн дэх заавал суралцах мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлүүдийн эзлэх хувийг дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 3. Хичээлүүдийн эзлэх хувь

	Хичээлийн төрөл	1998	2007	2014	2016
1	Эрх зүй	31,8	25	16	12,5
2	Менежмент	13,6	12,5	8	8,3
3	Төрийн удирдлага	36,4	45,8	52	62,5
4	Бусад	18,2	16,7	24	16,6

Эх сурвалж: Зохиогчийнхоор

Эндээс үзвэл Эрх зүй, менежментийн хичээлүүдийн эзлэх хувь буурсан, төрийн удирдлагын шинжлэх ухааны хичээлүүдийн эзлэх хувь өссөн, бусад хичээлүүдийн эзлэх хувь ерөнхийдөө тогтвортой байгаа дүр зураг ажиглагдлаа. Бусад хичээлүүдэд эдийн засаг, бизнесийн төрлийн хичээлүүд давамгайлж байна.

3. Хөтөлбөрийн шууд харьяалагдах нэгжийн өөрчлөлт. “Төрийн захиргааны менежмент” мэргэжил нь 1998-2002 онуудад “Үйлдвэрлэлийн технологийн удирдлага”-ын тэнхимд харьяалагдаж байгаад 2002 оноос “Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлага”-ын профессорын багт харьяалагдах болсон. 2014 оноос “Нийгмийн ухааны салбар” - т харьяалагдаж байна. Эндээс сургуулийн дотоод бүтэц, зохион байгуулалттай холбоотойгоор тухайн хөтөлбөрийн харьяалагдаж байсан нэгж өөрчлөгдөж байсныг харж болно.

Тухайн хөтөлбөр ямар нэгжид харьяалагдаж байгаагаас, ямар мэргэжлийн багш нар түлхүү хичээл зааж байгаагаас шалтгаалж, сургалтын төлөвлөгөөн дэх хичээлүүдэд онцын өөрчлөлт ордоггүйг нь дээрх судалгаанаас харагдаж байна.

Сургуулийн номын сангийн фондод байгаа мэргэжлийн ном, сурах бичгийн хангамжийг судалж үзэхэд 13 хичээлийн нийт 656 ширхэг ном байна. Эдгээрээс төр хувийн хэвшлийн түншлэл, засгийн газрын худалдан авах ажиллагаа хичээлийн ном, сурах бичиг огт байхгүй, цахим засаглал хичээлийн ном, сурах бичиг 4 байх жишээтэй [18]. Иймд сургуулийн зүгээс мэргэжлийн ном, сурах бичгийн хангамжийг сайжруулах тал дээр анхаарах хэрэгтэй байна.

4. Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал. Төрийн удирдлага мэргэжлээр 2017-2018 оны байдлаар нийт 232 бакалавр, 109 магистр төгссөн байна.

Хүснэгт 4. Төрийн удирдлага хөтөлбөрөөр тагсөгчдийн тоо

Төгссөн хичээлийн жил	Бакалавр	Магистр
2000-2001		1
2001-2002	5	3
2002-2003	15	2
2003-2004	19	1
2004-2005	22	6
2005-2006	22	2
2006-2007	15	3
2007-2008	17	2
2008-2009	24	1
2009-2010	8	1
2010-2011	3	11
2011-2012	0	5
2012-2013	8	27
2013-2014	16	9
2014-2015	10	8
2015-2016	20	14
2016-2017	18	5
2017-2018	10	8
Нийт	232	109

Эх сурвалж: Зохиогчийнхоор

Төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл /судалгаанд 214 төгсөгч хамрагдсан/ 30 хувь нь төрийн байгууллагад, 41 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад, 4,6 хувь нь хувиараа бизнес эрхлэгч, 7,5 хувь нь мэргэжил дээшлүүлэн суралцагч, 4,6 хувь нь улс төрийн байгууллага, 2 хувь нь олон улсын байгууллага, 4,6 хувь нь гадаадад амьдарч байгаа төгсөгчид, 3,7 хувь нь ажил эрхлээгүй, 5 хувь нь тодорхойгүй гэсэн судалгааны үр дүнгээс харахад 91,3 хувийн ажил эрхлэлттэй байна [19]. Гэхдээ төрийн удирдлага мэргэжлээр төгсчихөөд 30 хувь нь төрийн байгууллагад ажиллаж байгаа нь чамлалттай боловч төгсөгчдийн хөрвөх чадвар сайн гэдэг дүгнэлтэд хүрч байна. “Төрийн удирдлага” хөтөлбөрийн өөрчлөлт шинэчлэлийн хувьд дараах судалгааны үндэслэл, арга зүйд тулгуурлан тухайн асуудлыг авч үзсэн болно.

1. Баримт бичих судлах болон судалгааны түүхчилсэн аргын үүднээс авч үзвэл 1990-ээд оноос Боловсролын системд нэвтэрсэн шинэчлэлийн нэг болох “дээд боловсролыг лебиралчилах” бодлогын үүднээс “Дээд боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, судалгааны чиглэлийг нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоно”, “Олон улсын стандартад нийцсэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй болгох” зэрэг зорилтын хүрээнд төрийн удирдлага хөтөлбөрөөр мэргэжил бэлтгэх нь нээлттэй болсноор өнөөдөр 10 гаруй их дээд сургуульд тус хөтөлбөр хэрэгжиж хөдөлмөрийн зэх зээл дээр тухайн мэргэжлтний өрсөлдөөн бий болж мэргэжилтэн чанаржиж байна [20].

2. “Өрсөлдөх чадвартай дээд боловсрол” төслийн хүрээнд авч үзвэл их дээд сургуулиудын мэргэжилтэн бэлтгэж буй хөтөлбөрийн өөрчлөлт, төлөвлөгөө, мэргэжлийн нэршил, тухайн мэргэжлийн хөтөлбөрийн удирдлага харъяаллын асуудлыг харьцуулан судалсан болно.

3. Төрийн удирдлага мэргэжлийн хөтөлбөрийн судалгаа нь тухайн сургуулиас зохион байгуулсан 4 удаагийн мэргэжлийн хэлэлцүүлэг, семинарийн үд дүнд тулгуурлан дээд сургуулиудаар бэлтгэж буй мэргэжилтний чанар сайжруулах, мэргэжлийн багш нарын мэдлэгийн дамжуулах, мэдлэгийн менежментийг хөгжүүлэх, туршлага солилцох практик аргачилалд тулгуурласан судалгааны ажил юм.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Энэхүү судалгаа нь манай сургуулийн Төрийн удирдлага хөтөлбөрийн хувьд урд нь хийгдэж байгаагүй бөгөөд хөтөлбөрийн орчны хүрээнд 2018 оны төгсөгч Б.Жаргалмаагийн “Төрийн удирдлага хөтөлбөрийн мэргэжлийн ном, сурах бичгийн хангамжийн судалгаа”, хөтөлбөрийн үнэлгээний хүрээнд мөн оны төгсөгч Н.Буянтогтохын “Төрийн удирдлага мэргэжлээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа” гэсэн бакалаврын дипломын ажлуудыг дурдаж болно.

Тус өгүүлэлд тусгайлан судалгааны таамаглал дэвшүүлээгүй бөгөөд өнөөгийн бодит байдлыг судлахыг чухалсан. Мөн сургалтын хөтөлбөрийн үндсэн 4 бүтэц тус бүр дэх агуулгыг бүрэн тусгахыг урьтал болгоогүй ба цөөн шалгуур үзүүлэлтээр жишээ авч судалгаа хийснийг дурдах хэрэгтэй.vb

Цаашид тус хөтөлбөрийг шинэчлэх, улам хөгжүүлэхийн тулд дараах асуудлыг шийдвэрлэх, хамтран ажиллах шаардлагатай гэж үзлээ.

1. ШУТИС-ийн “Төрийн удирдлага” хөтөлбөрийн хүрээнд:

- Гадаад, дотоод хамтын ажиллагааг сайжруулах
- Танилцах болон мэргэжлийн дадлагын чанарыг сайжруулах, дадлагын баазыг нэмэгдүүлэх
- Багш нарыг давтан сургах, туршлага судлуулах, судалгааны ажлыг нь дэмжих
- Мэргэжлийн “online” кабинет байгуулах
- Мэргэжлийн ном, сурах бичгийн хангамжийг нэмэгдүүлэх
- Сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулахдаа багш, оюутан, төгсөгч, ажил олгогчийн судалгаан дээр суурилах

2. Бусад сургуулиудын “Төрийн удирдлага” хөтөлбөрийн хүрээнд:

- Их дээд сургууль-Төрийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх

- Төрөөс санхүүжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдэд мэргэжлийн багш нарыг бодлогоор жигд, хүртээмжтэй хамруулах
- Төрийн албаны зөвлөлд “Төрийн удирдлага” мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиуд хамтарсан санал хүргүүлж, нэршил, төрийн албаны сонгон шалгаруулалтын мэргэжлийн жагсаалтад тус мэргэжлийг хамруулах зэрэг асуудлыг дэвшүүлэх
- Мэргэжлийн холбоо байгуулах зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

ДҮГНЭЛТ

Монгол улсын төрийн албаны хөгжил, төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлэлт, түүний чадвахжуулахад тухайн мэргэжилтний бэлтгэж буй их дээд сургуулиудын үүрэг, төгсөгчдийн мэдлэг, тоо чанар нь шууд болон шууд бус байдлаар хамараалтай билээ. ШУТИС-ийн хувьд Төрийн удирдлага хөтөлбөрөөр 20 жилийн хугацаанд бэлтгэсэн мэргэжилтнүүд тодорхой түвшинд үүргээ гүйцэтгэж байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна. Тухайн судалгааны хувьд:

1. Цаг үеийн шаардлагаар өөрчлөлт, шинэчлэл хийгдэх нь зүй ёсны үйл явц хэдий ч өнөөдрийг хүртэл тухайн мэргэжлийн нэгдмэл нэршил тогтоогүй, нийгмийн ухааны болон менежментийн шинжлэх ухааны алинд нь харъяалагдах нь тодорхой бус, судлаачид нь саналын зөрүүтэй байр суурьтай байгаа нь төгсөгчдийн ажил эрхлэлт, хөтөлбөрийн хөгжилд сөргөөр нөлөөлөхийг үгүйсгэх аргагүй юм.
2. Юуны өмнө төрийн удирдлага, төрийн захиргаа, нийтийн удирдлага, нийтийн захиргаа, төрийн захиргааны менежмент гэсэн нэр томъёоны зөрүүтэй байдал, судлаачдын байр суурийг нэгтгэх, төрийн удирдлага хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиудын хамтын ажиллагааг улам өргөжүүлэх, мэргэжлийн нэр хүндийг өсгөх
3. БСШУС-ын сайдын 2017 оны 06 сарын 29-ний өдрийн А/52 тоот тушаалаар бэлтгэж буй “Төрийн удирдлага (D041303)” хөтөлбөрийг хувийн хэвшлийн болон улсын их дээд сургуулиудын хэрхэн хэрэгжүүлэж буйд шинжилгээ хийх
4. Хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг хамтран шийдвэрлэх зорилгоор судалгаанд тулгуурлан дээд шатны байгууллага болон олон нийтэд мэдээлэл өгөх. Тухайлбал, төрийн албанд сонгон шалгаруулалтанд Төрийн удирдлагын бакалавр зэргийг шалгуурыг нэг үзүүлэлт болгох зэрэг практик санал дэвшүүлж буй нь төрийн албаны чадахуйн зарчимд нийцнэ хэмээн үзэж байна.
5. Төрийн албаны зөвлөл төрийн удирдлага мэргэжлийн хөтөлбөр хэрэгжүүлж буй их дээд сургуулиудтай хамтран ажиллах, их дээд

сургуулиудыг өөрийн бэлтгэж буй ижил төсөөтэй мэргэжлийн хөтөлбөрөөр хамтарсан хэлэлцүүлэг хийх, багш оюутны эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, онол практикийн маргаан мэтгэлцээн зохион байгуулах нь тухайн мэргэжлийн хөтөлбөрийн хувьд тулгамдсан асуудал болж байгааг гаргаж тавьснаараа ач холбогдолтой болно.

НОМ ЗҮЙ

- [1] <https://mecss.gov.mn/page/41/> Дээд боловсролын шинэчлэлийн зураглал 2010-2021.
- [2] Боловсрол судлал сэтгүүл. 2008. №4, 42 х.
- [3] Пүрэвдорж Ч. Багшлахуйн менежмент. УБ., 2013. 289 х.
- [4] Пүрэвдорж Ч. Багшлахуйн менежмент. УБ., 2013. 384 х.
- [5] Лувсандорж Ц. Киррикулим хөгжил ба боловсролын стандартчлалыг оновчлох асуудалд. УБ., 2013. 15 х.
- [6] Даваа Ж. Их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй. УБ., 2012. 11 х.
- [7] Боловсрол судлал сэтгүүл. Сургалтын хөтөлбөр боловруулах, хэрэгжүүлэх асуудал. УБ., 2004. 8 х.
- [8] Одмаа Д. Улс төр судлалын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх судалгаа, үр дүн. УБ., 2013. 48 х.
- [9] Candace Kaye. Didactic Constructivist Approaches to Curriculum, Instruction and Assessment. By ppt. University of Southern California. 2013. p 3.
- [10] <http://avetra.org.au/avstracts2006/pa> Homi Azemikhah. The 21st Century, the Competency Era and Competency Theory. P 1.
- [11] Санжаабадам С. *Боловсролын чанарын үнэлгээ, хэтийн төлөв*. ХХ зууны Монголын боловсрол судлал: туршлага ба сургамж. УБ., 2002. 357 х
- [12] <http://www.huffingtonpost.com/dr-robert-mendenhall/competency-based-learning> What is Competency-Based Education
- [13] <http://dare.uvu.vu.nl/bitstream/> Wim Kouwenhoven. Competency-based curriculum development in higher education
- [14] ШУТИС. Төрийн удирдлага. УБ., 2019. 29 х.
- [15] Нямдулам Т, Одмаа Д. Төрийн удирдлага-20. УБ., 2018. 6 х.
- [16] Одмаа Д. Төрийн удирдлага хөтөлбөрийн танилцуулга. УБ., 2018. 4 х.
- [17] <http://www.1212.mn> Их, дээд сургууль, коллежийн тоо хариуцлагын хэлбэрээр.
- [18] Жаргалмаа Б. Төрийн удирдлага хөтөлбөрийн мэргэжлийн ном, сурах бичгийн хангамжийн судалгаа бакалаврын төгсөлтийн ажлын автореферат. УБ., 2018. 14 х
- [19] Дээд боловсролын шинэчлэлийн зураглал /roadmap/ 2010 – 2021